

ХИЛИЙН УСЫГ ХАМГААЛАХ БОЛОН АШИГЛАХ ТУХАЙ
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар /цаашид хэлэлцэн тохирогч хоёр Тал гэнэ/,

эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр хоёр улсын сайн хөршийн харилцаа болон хилийн усыг хамгаалах зохистой ашиглах талаар хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор,

1988 оны II дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан Хятад, Монголын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хоорондын Гэрээг үндэслэн,

энэхүү Хэлэлцээрийг байгуулахаар шийдвэрлэж, дор дурдсан зүйлсийг хэлэлцэн тохиролцов.

Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт заасан "хилийн ус" гэж

1.Халх гол, Хэрлэн гол, Буйр нуур, Булган гол,

2.Хоёр улсын хилийг огтлон гарч байгаа болон хилийн шугамд орших нуур, гол, мөрөн, горхи болон бусад усыг хэлнэ.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал хилийн усыг хамгаалах, зүй зохистой ашиглах зорилгоор дараах чиглэлээр хамтын ажиллагааг явуулна.Үүнд:

- 1.Хилийн усны горим, нөөц, чанарын судалгаа,хэмжилт хийх;
- 2.Хилийн нуур, голын савын өөрчлөлтийг хэмжиж тодорхойлох;

3.Хилийн ус, усны амьтан, ургамлын нөөцийг судлах, хамгаалах, ашиглах;

4.Хилийн усны бохирдлыг хянан хэмжих, багасгах;

5.Хилийн усны ус ашиглалтын болон үерээс хамгаалах барилга, байгууламжийг хамгаалах, оновчтой ашиглах.

Гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд заасан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хоёр Тал дараах үйл ажиллагааг явуулна.Үүнд:

1.Хоёр Тал харилцан тохиролцсон өртөө, харуул, газарт хилийн усны чанар, горим, нөөц болон хилийн гол, нуур, тэдгээрийн савын өөрчлөлтийн байдалд хяналт, хэмжил явуулах;

2.Хамтын ажиллагааны хүрээнд технологи, техникийн баримт бичиг, мэдээ, зураг төсөл солилцох;

3.Төлөөлөгчид, мэргэжилтэн солилцож хамтарсан судалгаа, хэмжилтийн ажил хийх;

4.Хамтын судалгаа, туршилтын төв, хэсэг байгуулах.

Дөрөвдүгээр зүйл

1.Хэлэлцэн тохирогч хоёр Тал хилийн усны экологийн системийг хамтран хамгаалах бөгөөд нөгөө Талд хохирол учруулахгүй байдлаар хилийн усыг ашиглана.

Хилийн усыг ашиглахдаа ямар ч нөхцөлд шударга, зохистой байх зарчмыг баримтлах бөгөөд хилийн усыг зохистой ашиглаж байгаа байдалд хохирол учруулж болохгүй.

2.Хэлэлцэн тохирогч хоёр Тал хилийн усыг ашиглах аж ахуйн үйл ажиллагааг энэ Хэлэлцээрийн аравдугаар зүйлд заасан

Хилийн усны хамтарсан комиссын хурлаар хэлэлцэн тохиролцсоны дагуу явуулна.

Тавдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч хоёр Тал Буйр нуур болон түүний загасны нөөцийг эзэмших, ашиглах, хамгаалах талаар хамтран ажиллана.

2. Хэлэлцэн тохирогч хоёр Тал Буйр нуурын загасыг үржүүлэх, хамгаалах технологи боловсруулах талаар хамтран ажиллана.

3. Хэлэлцэн тохирогч хоёр Тал Буйр нуурын загас агнах асуудлаар жич хэлэлцэн тохиролцоно.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал усны үеэр, цэн түрэлт, үйлдвэрлэлийн осол зэрэг байгалийн болон хүний үйлдлийн улмаас хилийн усны чанар, нөөц, байгалийн горим болон усны амьтан, ургамалд учирч болзошгүй хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, багасгах, арилгах арга хэмжээ авна.

Долдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал хилийн уснаас жилд авч ашиглах усны хэмжээг тогтоож тохиролцоно. Хоёр Тал нэгэнт тохиролцсон жилд авч ашиглах усны хэмжээг хэтрүүлсэн үйл ажиллагааг өөр өөрийн нутагт явуулахгүй байх үр нөлөөтэй арга хэмжээ авна.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал хилийн усанд хамтын судалгаа, хэмжилт хийх өртөө, харуул, газар түүнчлэн солилцох мэдээллийн агуулга, тоо хэмжээ, хугацааг хэлэлцэн тохиролцоно.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Хэлэлцээрийн дагуу явуулсан хамтын ажиллагааны үр дүн, харилцан солилцсон мэдээлэл, техникийн баримт бичгийг чөлөөтэй ашиглана. Харин нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр аль нэг Тал түүнийг гуравдагч Талд шилжүүлж үл болно.

Аравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан өөр өөрийн нэг Төлөөлөгч, түүний хоёр орлогчийг томилон хилийн усны хамтарсан комисс байгуулж ажилдуулна.

Арван нэгдүгээр зүйл

Хилийн усны хамтарсан комиссын хурлыг хоёр жил тутам нэг удаа хоёр улсад ээлжлэн хийж, энэхүү Хэлэлцээрийн биелэлт, хилийн устай холбоотой асуудлыг хэлэлцэнэ. Хурлыг зохион байгуулагч улсын Төлөөлөгч зарлан хийлгэж, удирдана. Хоёр талын Төлөөлөгч мэргэжилтний тусалцаа авч болох бөгөөд тэднийг хуралд оролцуулж болно. Хурал хийх бүрт протоколыг хятад, монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж өөр өөрийн улсын Засгийн газарт мэдээлнэ. Шаардлагатай үед мэргэжилтний зөвлөлгөөн хийнэ.

Арван хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Хэлэлцээрийн дагуу төлөөлөгчид, мэргэжилтнийг солилцохдоо тэдний очих, буцах замын зардлыг илгээгч Тал, нөгөө Талын нутагт ажиллах хугацаанд хоол, байр, хотын тээврийн зардлыг хүлээн авагч Тал тус тус хариуцна.

Арван гуравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал тохиролцсоны дагуу энэхүү Хэлэлцээрт өөрчлөлт, нэмэлт оруулж болно.

Арван дөрөвдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудал гарвал хэлэлцэн тохирогч хоёр Тал найрснаар зөвлөлдөн шийдвэрлэнэ.

Арван тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал өөр өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу энэхүү Хэлэлцээрийг хүчинтэй болгоход шаардагдах ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд хоёр Тал нот солилдож харилцан мэдэгдсэн өдрөөс эхлэн энэхүү Хэлэлцээр нь арван жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэлэлцэн тохирогч хоёр Талны аль нэг нь нөгөө Талдаа Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас нэг жилийн өмнө түүнийг цуцлах тухай бичгээр эс мэдэгдвэл хүчинтэй байх хугацаа нь тав, таван жилээр аяндаа сунгагдах болно.

Энэхүү Хэлэлцээрийг *Улаанбаатар* хотноо 1994 оны сарын 29 -ны өдөр хятад, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ӨМНӨӨС

唐家璇